МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Засгийн газрын IX байр, Энхтайвны өргөн чөлөө 16а,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn,
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2026.10.01 № 01/3328

танай 2026.09.17-ны № 61 -т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ч.УНДРАМ ТАНАА

Таны 2026 оны 09 дүгээр сарын 17-ны 61 тоот албан бичгээр ирүүлсэн Органик бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн талаар асуулгатай танилцаад мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 24. хуудастай

Ц.ИДЭРБАТ

1301041713

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
Сайдын 2026 оны 10... дугаар сарын
01....ны өдрийн 01/3328 дугаар албан
бичгийн хавсралт

“ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН МЭДЭЭ

Асуулга 1-ийн хариулт: Органик бүтээгдэхүүний тухай хуулийг дагаж гарах захиргааны хэм хэмжээний акт болох нийт “Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист тавигдах шаардлага, тэдгээрийг үнэлэх аргачлал болон жагсаалт”, “Хамтын баталгаажуулалтын байгууллагад тавигдах шаардлага, түүнийг байгуулах, бүртгүүлэх, баталгаажуулалт хийх журам”, “Мэдээллийн санд баталгаажсан шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг бүртгүүлэх тухай журам”, “Органик бүтээгдэхүүний орц, найрлага тооцох аргачлал”, “Органик салбарын үндэсний зөвлөлийг байгуулах, ажиллах журам”, “Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журам”, “Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортод төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшуулал олгох журам”-ыг тус тус хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж тусгасан.

Үүнээс 2024-2026 онд батлагдсан 2025 оны 11 дүгээр сарын 20-ны А/591 дугаар тушаалаар ”Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журам”, 2024 оны 9 дүгээр сарын 09-ны А/545 дугаар тушаалаар “Мэдээллийн санд баталгаажсан шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг бүртгүүлэх тухай журам”, 2024 оны 9 дүгээр сарын 09-ны А/545 дугаар тушаалаар ”Баталгаажуулалтын гэрчилгээний загвар”-ыг, 2026 оны 03 дугаар сарын 03-ны А/67 дугаар тушаалаар “Хамтын баталгаажуулалтын байгууллагад тавигдах шаардлага, түүнийг байгуулах, бүртгүүлэх, баталгаажуулалт хийх журам”, 2026 оны 03 дугаар сарын 03-ны А/68 дугаар тушаалаар хуулийн “Органик салбарын Үндэсний зөвлөлийг байгуулах, ажиллах журам”-ыг тус тус батлуулан мөрдөж ажиллаж байна.

2026 онд батлуулахаар төлөвлөн ажиллаж буй ”Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортод төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшуулалтай холбогдох журам”-ыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, сайдын тушаалын төслийг албан хэрэг хөтлөлтийн цахим системд байршуулан 2026 оны 09 дүгээр сард батлуулахаар удирдлагуудад танилцуулан албажуулж байна. ”Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист тавигдах шаардлага, тэдгээрийг үнэлэх аргачлал болон жагсаалт”, Органик бүтээгдэхүүний орц, найрлага тооцох аргачлал”, ”Мэдээллийн санд баталгаажсан шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг бүртгүүлэх тухай журам”-ыг тус тус шинэчлэн батлуулахаар боловсруулан олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос санал авахаар https://www.mofa.gov.mn/law/tosol яамны цахим системд байршуулан санал авч байна.

Асуулга 2-ын хариулт: Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн төлбөр төлөх эрх зүйн үндэслэл бүрдээгүй. Тухайлбал Монгол Улсын Засгийн газрын “Олон улсын байгууллага, гэрээ, конвенцын итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай” 2007 оны 60 дугаар тогтоолын хавсралт 1 “Татварыг нь улсын төсвөөс төлөх олон улсын байгууллагуудын жагсаалт”-д ороогүй болно.

“Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн 22.5.20.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн “4.1.2-т органик бүтээгдэхүүнийг

үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсэн эхний таван жилд 100 хувиар, дараагийн таван жилд 50 хувиар хөнгөлнө".гэсэн заалтыг Сангийн яамнаас батлуулан мөрдөж байна. /Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./ Татварын ерөнхий газраас мэдээллийг авах боломжтой юм.

Бусад асуулгад туссан зардал нь Хуулийн 16 дугаар зүйлийн 16.3."Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортод төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшуулалтай холбогдох журам"-ыг батлуулахаар албажуулж байгаа бөгөөд батлагдсан тохиолдолд улсын төсөвт жилд дунджаар 500 сая төгрөгөөс 1 тэрбум төгрөгийн дүн тавигдаж үүсэх тул энэ асуудлыг төсөвт суулгаж, шийдвэрлэхэд таны зүгээс дэмжүүлэх саналтай.

Асуулга 3-ын хариулт: ХХААХҮЯ-ны өмчлөлд байгаа органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийн шийдвэрийн хэрэгжилт:

Хамтын баталгаажуулалтын байгууллагын олгох "100% органик бүтээгдэхүүн", "Органик Монгол бүтээгдэхүүн", "Органик хоол, үйлдвэрлэл, үйлчилгээ", "Органик үйлчилгээ", "Шилжилтийн үеийн органик Монгол бүтээгдэхүүн", "Шилжилтийн үеийн Органик Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ"-ний гэрчлэх тэмдгийг;


МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ


МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагын олгох "Баталгаажсан Монгол 100% органик бүтээгдэхүүн", "Баталгаажсан Монгол органик бүтээгдэхүүн", "Баталгаажсан Органик хоол, үйлдвэрлэл, үйлчилгээ", "Баталгаажсан Органик үйлчилгээ", "Шилжилтийн үеийн Монгол органик бүтээгдэхүүн", "Шилжилтийн үеийн Органик Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ"-ний гэрчлэх тэмдгийг; тус тус Монгол Улсын Оюуны өмчийн газрын 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/79 тоот тушаалаар тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгосон. (дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав)



МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ



МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Асуулга 4-ийн хариулт: Хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний баталгаажуулалтыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны А/591 дугаар тушаалаар батална "Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журам"-аар зохицуулж байна. Уг журмаар Хөдөө аж ахуйн болон байгалийн гаралтай органик хүнс, хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн, мал, амьтан, тэжээл, бордоо, таримлын үр, суулгац, ойн дагалдах баялаг болон байгалийн ургамлыг органик зарчимд нийцүүлэн үржүүлэх, үйлдвэрлэх, бэлтгэх, түүж ашиглах, боловсруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, байгалийн тээвэрлэх, хадгалах, савлах, шошголох, худалдаалах, экспортлох, импортлох ажиллагааг зохицуулж байна.

Асуулга 5-ын хариулт: Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллагуудаас бүртгэл, мэдээллийн санд нийт 200 орчим га талбайд органик бүтээгдэхүүнийг хүлэмжийн болон талбайн зориулалтаар ашиглаж байна. Энэ нь нийт нийт хүнсний ногооны тариалангийн талбайн хэмжээний 1,7%-ийг эзэлж байна.

Асуулга 6-ын хариулт: Органик бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Торгоны замын энхийн элч" Төрийн бус байгууллагатай хамтран Торгоны замын бүс нутгийн орнуудын агроэкологийн интеграци, тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлох ач холбогдол бүхий "Төв Азийн органик форум-3" олон улсын чуулга уулзалтыг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо 2026 оны 8 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. Уг арга хэмжээгээр органик үйлдвэрлэл эрхлэгч, тариаланчид, малчдын төлөөлөл, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл, Энэтхэг, Казахстан, Киргизстан, Тажикстан, Туркменистан, БНХАУ, БНСУ зэрэг улс орнуудын албаны төлөөлөл болон бизнесийн байгууллагын төлөөллүүд хамтарсан үзэсгэлэн, "B2B" уулзалтуудыг зохион байгуулж оролцсон. Уг форумын гол ач холбогдол нь Төв Азийн орнуудын органик бүтээгдэхүүний хамтын ажиллагааг нэгтгэх, судлах өндөр ач холбогдолтой байлаа.

Хамтын ажиллагааны хүрээнд "Монпеллетс" ХХК, "Шэйр Монголиа" ТББ хооронд Харилцан ойлголцлын санамж бичиг (MoU) байгуулсан. Талууд хонины ноосыг ашиглан органик бордоо үйлдвэрлэх, ноосны санамж бичгийн хүрээнд талууд хонины ноосонд суурилсан органик бордоо үйлдвэрлэлийг хөгжүүлэх,

ноосны салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэдлэг, туршлага солилцох, олон улсын дадлага, сургалтын хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх, мөн Киргиз Улсад дэвшилтэт технологи нэвтрүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцов.

Энэхүү хамтын ажиллагаа нь ногоон өртгийн сүлжээг бэхжүүлэх, орон нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих, холбооны гишүүдэд шинэ боломж бий болгох стратегийн ач холбогдолтой алхам болж байна. Түүнчлэн бүс нутгийн хэмжээнд байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулах үндэс суурийг бүрдүүлж байна.

Цаашид органикийн салбарын олон улсын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх, үйлдвэрлэлээс экспорт хүртэлх ногоон өртгийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэгчдийн чадавхыг бэхжүүлэх, хөрөнгө оруулалт болон технологийн хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Гадаад харилцааны яам, элчин төлөөлөгчийн газруудаар дамжуулан анхаарал хандуулах шаардлагатай байна.

Асуулга 7-ын хариулт: Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт тусгасан “Бүтээгдэхүүний шошгод монгол болон гадаад хэлээр бичигдсэн "органик", "байгалийн цэвэр", "байгалийн гаралтай цэвэр", "эко", "ногоон", "экологийн гаралтай", "экологийн цэвэр", "экологийн", "био", "биологийн", "биологийн гаралтай", "биологийн цэвэр" гэсэн үг болон эдгээртэй агуулгын хувьд дүйцэх үгийг хэрэглэх бол энэ хуулийг дагаж мөрдөнө.” гэж; 13.7 дахь хэсэгт “Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 13.6 дахь хэсэгт заасан үг болон эдгээртэй агуулгын хувьд дүйцэх үгийг хуулийн этгээдийн нэрээр баталгаажуулахгүй.” гэж тус тус заасны заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт “Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 02/1574 тоот албан бичгийг хүргүүлж, хамтран ажиллаж байна. (хавсаргав)

Хяналтын тогтолцоотой холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн “Баяжуулсан болон органик хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” “хяналт шалгалтын удирдамж”-ийг 2026 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 08-00-02/19 дугаараар баталсан.

Энэ үйл ажиллагааг “Салбарын хяналт шалгалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 4 дүгээр сарын 08-ны 115 дугаар тогтоолоор цуцлалсан.

Асуулга 8-ын хариулт: 2026 оны 3 дугаар сарын 03-ны А/68 дугаар тушаалаар “Органик салбарын Үндэсний зөвлөлийг байгуулах, ажиллах журам”-ыг баталсан. Тушаалд үндэслэн Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлахаар мэргэжлийн холбоодоос нэр авахаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 02/1788 тоот албан бичгийг хүргүүлсэн.

Хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангуулахаар Боловсролын яаманд 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 02/1576 тоот, Гаалийн ерөнхий газарт 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 02/1575 тоот, Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 02/1577 тоот, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимд 2025 оны 5 дугаар сарын 22-ний өдрийн 02/1606 тоот, мөн Боловсролын яаманд “Хуулийн хэрэгжилтийг хангаж, холбогдох зардлыг жил бүрийн улсын төсөвт суулгаж ажиллах талаар албан хүсэлтийг 2026 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 01/2236 тоот албан бичгийг тус тус хүргүүлж ажиллаж байна. (хавсаргав).

Мөн “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай” хуулийн 7.1.3.-т сургуулийн хоол үйлдвэрлэлийн хүнсний хангамжид энэ хуулийн 7.1.1-д заасан шаардлагыг хангасан органик, орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжид хэрэглэх; */Энэ заалтад 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар “орон нутгийн” гэсний өмнө “органик,” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./*

Асуулга 9-ийн хариулт: Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн шинэчлэл, хүнсний аюулгүй байдлын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх талаар хийгдэж буй ажил, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэл

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын цогц бодлогын нэг хүнсий аюулгүй байдлыг хангахад хүнсний аюулгүй байдал, хангамж, иргэдийн эрүүл, зөв амьдрал, хүний бие махбодын хэрэгцээ, шаардлагад нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах асуудал чухал байр суурь эзэлдэг.

Энэхүү зорилтын хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд хүнсний аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг тусгайлан тусгасан байна. Тухайлбал, "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.4.2.1, "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын 2.5 дахь зорилтод баталгаат хүнсээр хангах талаар тус тус заасан.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхтэй холбоотой заалтыг тусгасан бөгөөд холбогдох хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулан ажиллаж байна.

Хууль тогтоомжийн шинэчлэл ба онцлох зохицуулалтууд

Монгол Улсын Их Хурал 2012 онд Хүнсний тухай хуулийг шинэчлэн баталсан хэдий ч тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хүнсний сүлжээний баталгаат байдал, хүн амын бодит хэрэглээтэй холбоотой зарим зохицуулалт орхигдсон байдаг.

Иймд хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор УИХ-ын гишүүн М.Мандхайн санаачилсан Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр эцэслэн батлагдаад байна. Тус хуульд дараах онцлох зохицуулалтууд тусгагдсан. Үүнд:

- Хүнсний хангамжийг тодорхойлохдоо нялх, балчир хүүхдийн хоол тэжээл болон цэцэрлэг, сургуулийн хүнсний хүртээмжийн асуудлыг нэн тэргүүнд авч үзэх;
- Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд дотоодын түүхий эд ашиглан, стандартын шаардлага хангасан хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн нийлүүлсэн аж ахуйн нэгж, хоршоонд төрөөс дэмжлэг, урамшуулал олгох;
- Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журмыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх;

- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлагыг дээшлүүлж, салбар хоорондын уялдааг хангах мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;
- Хүнсний чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэн үр дүнг нь хүнсний аюулгүй байдлыг хангахад ашигласнаар импортын хамаарлыг бууруулах, байгууллагын эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох .

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Лүндэг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхтэй холбогдуулан хуулийн төсөлд салбарын яамнаас холбогдох саналыг тусган хүргүүлээд байна. Үүнд:

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын талаарх нэр томьёо, ойлголтыг нэгтгэж, олон улсад баримталдаг суурь ойлголт, жишигт нийцүүлэхээр нэр томьёотой холбоотой санал.

Улс дамнан хоол хүнсний хордлого, халдварт өвчний дэгдэлт, аюултай бодисын бохирдол үүсэх үед улс орнууд энэхүү сүлжээгээр дамжуулан мэдээллийг шуурхай солилцож, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой Олон Улсын хүнсний аюулгүй байдлын байгууллагуудын сүлжээ (ИНФОСАН)-тай мэдээлэл солилцох зохицуулалтыг тусгах.

Олон улсын сүлжээнд мэдээлэх, хүнсний аюулгүй байдлын сүлжээгээр дамжуулан эрсдэл үүссэн үед хариу арга хэмжээ авах Үндэсний зохицуулагч болон мэргэжилтнүүдийг томилох, нөхцөл байдлыг олон нийтэд мэдээлэх, аюулгүй байдлыг зэрэглэх, хүний нөөцийг чадавхжуулах зэрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг бий болгох зэрэг болно.

Түүнчлэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэндийг хамгаалах замаар хүнсний аюулгүй байдлыг хангах, худалдааны чөлөөт байдлыг дэмжих, байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахаар Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хурлаар соёрхон баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд хүүхдийн хоол, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгохтой холбогдсон асуудлыг зохицуулахаар нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Боловсролын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталсан.

Дээрх хууль, тогтоомжийг хэрэгжилтийг хангах хүрээнд Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2026 оны 02 дугаар зөвлөмжөөр “Хүнсний аюулгүй байдлыг хангах, салбар дундын тандалтын 2026-2028 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г дэмжин баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Олон улсын хамтын ажиллагаа ба стандартчилал

Монгол Улсын санаачилгаар Кодекс Алиментариус Комиссын 49 дүгээр чуулган (CAC49)-аар чацарганы үрийн болон жимсний зөөлөн эдийн тосны стандарт боловсруулах ажил албан ёсоор дэмжигдсэн байна.

Үүний үр дүнд "Named Vegetable Oils" (CXS 210) стандартад чацарганы хоёр төрлийн тосны стандартыг тусгах үйл явц эхэлсэн бөгөөд гишүүн орнуудын оролцоотойгоор үе шаттайгаар хэлэлцүүлж, батлуулах юм.

Мөн Олон Улсын Хүнсний хууль эрх зүйн хорооноос "Ингэний ариутгасан сүүний Кодексийн стандарт" боловсруулах санаачилгыг баталсан нь үндэсний онцлог бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах, малчдын амьжиргааг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой алхам болж байна.

Үүний зэрэгцээ, 2026 оны 6 дугаар сарын 23-ны өдөр БНХАУ-ын Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний үндэсний төв (CFSA) болон Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хооронд Санамж бичиг байгуулсан нь хоёр улсын хүсний аюулгүй байдлын чиглэлээрх хамтын ажиллагаа шинэ түвшинд гарч, Үндэсний Кодексын хорооны үйл ажиллагааг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах юм.

Хүнсний тухай болон холбогдох бусад хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь хүн амыг баталгаат хүнсээр хангах, ялангуяа хүүхдийн хоол тэжээлийн аюулгүй байдлыг сайжруулах, дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зэрэг чухал зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, үндэсний онцлогтой бүтээгдэхүүн болох чацарганы тос, ингэний сүү зэрэгт олон улсын стандарт батлуулах санаачилга гаргасан нь Монгол Улсын хүнсний экспортын чадавхыг нэмэгдүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг өсгөх стратегийн өндөр ач холбогдолтой юм.

Цаашид батлагдсан хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг үе шат бүрд тогтмол хянаж, салбар дундын уялдаа холбоо, мэдээлэл солилцоог сайжруулах нь хүнсний аюулгүй байдлын тогтолцоог бүрэн утгаар нь төлөвшүүлж, эрүүл нийгмийг цогцлоох үндсэн нөхцөл болно.

Асуулга 10-ын хариулт: Хэрэглэгчдэд органик хэрэглээний боловсрол олгох, хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх, худалдааг дэмжих зорилгоор хийж буй ажлуудаас дурдахад:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас жил бүр зохион байгуулдаг “Намрын ногоон өдрүүд – Үндэсний үйлдвэрлэл 2026” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж байна. Энэ арга хэмжээ нь үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, дотоодын үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах, хэрэглэгчдэд үндэсний үйлдвэрлэлийн чанартай бүтээгдэхүүнийг сонгон хэрэглэхийг уриалах зорилгоор зохион байгуулдаг бөгөөд органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид энэхүү арга хэмжээнд хамрагдаж байна.

Олон улсын түвшинд дээр дурдсан “Торгоны замын энхийн элч” Төрийн бус байгууллагатай хамтран “Төв Азийн органик форум-3” олон улсын үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулахад яамнаас дэмжиж ажиллалаа.

Төвийн бүсийн Хөвсгөл, Сэлэнгэ аймгууд “Органик хүнс хөтөлбөр”-ийг батлуулан мөрдөж ажиллаж байна. Тухайлбал: Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 07 дугаар сарын 31-ний XXVII/35 дугаар тогтоолоор, Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2026 оны 01 дүгээр сарын 30-ны 75 дугаар тогтоолоор тус тус батлуулж, мөрдөж ажиллаж байна.

21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нартай хийх уулзалтаар Органик үүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарах тухай танилцуулга хийлээ. Мөн Азийн хөгжлийн банкны хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2026 оны Сэлэнгэ, Дархан-Уул, Хөвсгөл аймгуудад төрийн байгууллага болон үйлдвэрлэгчдэд органикийн салбарын өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар танилцуулга хийж, уулзалт зохион байгуулж ажиллав.

Цаашлаад Нийслэл, 21 аймгийн хэмжээнд “Органик хүнс хөтөлбөр”-ийг батлуулж, мөрдлөг болгон худалдааны болон боловсролын байгууллагуудаар дамжуулан хэрэглэгчдэд органик хэрэглээний боловсрол олгох, мэдлэгийг түгээхийг уриалга болголоо.

МОНГОЛ УЛСЫН
ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛЧИЛГЭЭРИЙН ЯАМ

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16а,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2025.05.21 № 02/1576

танай -ны № -т

БОЛОВСРОЛЫН ЯАМАНД

Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны нэгдсэн чуулганаар "Органик бүтээгдэхүүний тухай" /Шинэчилсэн найруулга/ хуулийг батлуулсан бөгөөд уг хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлээд байна.

Хуулийн дөрөвдүгээр бүлэг "Органик бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчид үзүүлэх дэмжлэг, урамшуулал"-ийн 16 дугаар зүйлийн "16.2.1.сургуулийн өмнөх болон бүх шатны боловсролын байгууллагын дэргэд органик туслах аж ахуйг хөгжүүлэх;" гэж;

"16.4.Энэ хуулийн 16.2.1-д заасан дэмжлэг үзүүлэх асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцаж хэрэгжүүлнэ." гэснийг болон бусад заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Т.ЖАМБАЛЦЭРЭН

МОНГОЛ УЛСЫН
ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХОНГОН УЙЛДВЭРИЙН ЯАМ
Засгийн газрын IX байр, Энхтайвны өргөн чөлөө 16а,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2025.05.21 № 02/1577

танай _____-ны № _____-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА НАРТ

**Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны нэгдсэн чуулганаар "Органик бүтээгдэхүүний тухай" /Шинэчилсэн найруулга/ хуулийг батлуулсан бөгөөд уг хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлээд байна.

Хуулийн дөрөвдүгээр бүлэг 15 дугаар зүйл.Төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг хэсгийн "15.1.Органик үйлдвэрлэлийн бодлого, эрх зүйн зохицуулалтыг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүргийг улсын хэмжээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн нэгж хариуцан гүйцэтгэнэ." гэж; "15.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих талаар тухайн орон нутгийг хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулан, үр дүнг мэдээллийн санд оруулна." гэснийг болон бусад заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Т.ЖАМБАЛЦЭРЭН

1301051159

МОНГОЛ УЛСЫН
ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Засгийн газрын IX байр, Энхтайвны өргөн чөлөө 16а
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2026.06.29 № 01/2236
танай _____-ны №_____-т

БОЛОВСРОЛЫН САЙД
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

**Хуулийн хэрэгжилтийг
хангаж ажиллах тухай**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны нэгдсэн чуулганаар "Органик бүтээгдэхүүний тухай" /Шинэчилсэн найруулга/ хуулийг батлуулсан бөгөөд уг хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлээд байна.

Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-т сургуулийн өмнөх болон бүх шатны боловсролын байгууллагын дэргэд органик туслах аж ахуйг хөгжүүлэх гэж мөн хуулийн 16.4-т Энэ хуулийн 16.2.1-д заасан дэмжлэг үзүүлэх асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцаж хэрэгжүүлнэ. гэж тус тус заасан.

Иймд "Органик бүтээгдэхүүний тухай" хуулийн дээрх заалт болон Төсвийн тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлд Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрхийн хүрээнд дээрх асуудлыг санхүүжүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвтөө тусган хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг хүсье.

Ц.ИДЭРБАТ

МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16а
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn,
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2025.05.21 № 02/1575

танай _____-ны №_____-т

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны нэгдсэн чуулганаар "Органик бүтээгдэхүүний тухай" /Шинэчилсэн найруулга/ хуулийг батлуулсан бөгөөд уг хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлээд байна.

Хуулийн гуравдугаар бүлэг 12 дугаар зүйл.Органик бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн сан хэсгийн "12.3.Гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлсэн органик бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээллийг мэдээллийн санд илгээнэ." гэснийг болон бусад заалтуудын хэрэгжилтийг хангаж хамтарч ажиллана уу.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Т.ЖАМБАЛЦЭРЭН

МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Засгийн газрын IX байр, Энхтайвны өргөн чөлөө 16а
Баянзүрх дүүрэг, улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn,
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2025.05.22 № 02/1606

танай _____-ны № _____-т

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМД

Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны нэгдсэн чуулганаар "Органик бүтээгдэхүүний тухай" /Шинэчилсэн найруулга/ хуулийг батлуулсан бөгөөд уг хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлээд байна.

Энэ хуулиар хөдөө аж ахуйн болон байгалийн гаралтай органик хүнс, хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн, мал, амьтан, тэжээл, бордоо, таримлын үр, суулгацыг үржүүлэх, үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, тээвэрлэх, хадгалах, савлах, шошголох, худалдаалах, экспортлох, импортлох үйл ажиллагаанд үйлчлэх тухай асуудлыг бүхэлд нь зохицуулсан болно.

Иймд танай байгууллагын 2018 оны А/181 тоот тушаалаар Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын даргын баталсан "Бүтээгдэхүүнд "Органик бүтээгдэхүүн /certified organic" эко шошго хэрэглэх эрх олгох журам"-ын хүрээнд хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүнд олгодог эрхийг хүчингүй болгож, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Т.ЖАМБАЛЦЭРЭН

МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХОНГОН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Засгийн газрын IX байр, Энхтайвны өргөн чөлөө 16а
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn,
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2025.05.21 № 02/1574

танай _____-ны №_____-т

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗАРТ

Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны нэгдсэн чуулганаар "Органик бүтээгдэхүүний тухай" /Шинэчилсэн найруулга/ хуулийг батлуулсан бөгөөд уг хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлээд байна.

Хуулийн гуравдугаар бүлэг "Органик бүтээгдэхүүний баталгаажуулалт, бүртгэл, мэдээллийн сан, шошго"-ийн 13 дугаар зүйлийн 13.6.Бүтээгдэхүүний шошгод монгол болон гадаад хэлээр бичигдсэн "органик", "байгалийн цэвэр", "байгалийн гаралтай цэвэр", "эко", "ногоон", "экологийн гаралтай", "экологийн цэвэр", "экологийн", "био", "биологийн", "биологийн гаралтай", "биологийн цэвэр" гэсэн үг болон эдгээртэй агуулгын хувьд дүйцэх үгийг хэрэглэх бол энэ хуулийг дагаж мөрдөнө." гэж;

"13.7.Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 13.6-д заасан үг болон эдгээртэй агуулгын хувьд дүйцэх үгийг хуулийн этгээдийн нэрээр баталгаажуулахгүй." гэснийг болон бусад заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Т.ЖАМБАЛЦЭРЭН

1301051429

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын **2025 оны 6 сарын 30**-ны өдрийн **А/79** тоот тушаалаар тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов.

Улсын бүртгэлийн дугаар:	**40-0031666**
Мэдүүлгийн бүртгэлийн дугаар :	**40-2024-0036836**
Анхдагч огноо :	**2024.10.15**
Эзэмшигчийн нэр :	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам**
Эзэмшигчийн хаяг :	**Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр**
Хүчинтэй байх хугацаа :	**2034.10.15**
Бараа, үйлчилгээний олон улсын ангилал :	**42**
Гэрчлэх тэмдэг:	

ОРГАНИК
Монгол бүтээгдэхүүн

ДАРГА Г.ЭЛБЭГСАЙХАН

0013347

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын **2025 оны 6 сарын 30**-ны өдрийн **А/79** тоот тушаалаар тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов.

Улсын бүртгэлийн дугаар:	**40-0031670**
Мэдүүлгийн бүртгэлийн дугаар :	**40-2024-0036840**
Анхдагч огноо :	**2024.10.15**
Эзэмшигчийн нэр :	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам**
Эзэмшигчийн хаяг :	**Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр**
Хүчинтэй байх хугацаа :	**2034.10.15**
Бараа, үйлчилгээний олон улсын ангилал :	**42**
Гэрчлэх тэмдэг:	

ОРГАНИК
Үйлчилгээ

ДАРГА Г.ЭЛБЭГСАЙХАН

0013343

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын **2025 оны 6 сарын 30**-ны өдрийн **А/79** тоот тушаалаар тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов.

Улсын бүртгэлийн дугаар:	**40-0031669**
Мэдүүлгийн бүртгэлийн дугаар :	**40-2024-0036839**
Анхдагч огноо :	**2024.10.15**
Эзэмшигчийн нэр :	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам**
Эзэмшигчийн хаяг :	**Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр**
Хүчинтэй байх хугацаа :	**2034.10.15**
Бараа, үйлчилгээний олон улсын ангилал :	**42**
Гэрчлэх тэмдэг:	

ОРГАНИК
Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ

ДАРГА Г.ЭЛБЭГСАЙХАН

0013344

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын **2025 оны 6 сарын 30**-ны өдрийн **А/79** тоот тушаалаар тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов.

Улсын бүртгэлийн дугаар:	**40-0031672**
Мэдүүлгийн бүртгэлийн дугаар :	**40-2024-0036842**
Анхдагч огноо :	**2024.10.15**
Эзэмшигчийн нэр :	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам**
Эзэмшигчийн хаяг :	**Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр**
Хүчинтэй байх хугацаа :	**2034.10.15**
Бараа, үйлчилгээний олон улсын ангилал :	**42**
Гэрчлэх тэмдэг:	

ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН ОРГАНИК
Монгол бүтээгдэхүүн

ДАРГА Г.ЭЛБЭГСАЙХАН

0013341

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын **2025 оны 6 сарын 30**-ны өдрийн **А/79** тоот тушаалаар тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов.

Улсын бүртгэлийн дугаар:	**40-0031673**
Мэдүүлгийн бүртгэлийн дугаар :	**40-2024-0036843**
Анхдагч огноо :	**2024.10.15**
Эзэмшигчийн нэр :	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам**
Эзэмшигчийн хаяг :	**Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр**
Хүчинтэй байх хугацаа :	**2034.10.15**
Бараа, үйлчилгээний олон улсын ангилал :	**42**
Гэрчлэх тэмдэг:	

ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН ОРГАНИК

ДАРГА Г.ЭЛБЭГСАЙХАН

0013340

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын **2025 оны 6 сарын 30**-ны өдрийн **А/79** тоот тушаалаар тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов.

Улсын бүртгэлийн дугаар:	**40-0031663**
Мэдүүлгийн бүртгэлийн дугаар :	**40-2024-0036833**
Анхдагч огноо :	**2024.10.15**
Эзэмшигчийн нэр :	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам**
Эзэмшигчийн хаяг :	**Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр**
Хүчинтэй байх хугацаа :	**2034.10.15**
Бараа, үйлчилгээний олон улсын ангилал :	**42**
Гэрчлэх тэмдэг:	

БАТАЛГААЖСАН
Монгол 100% ОРГАНИК бүтээгдэхүүн

ДАРГА Г.ЭЛБЭГСАЙХАН

0013349

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын **2025 оны 6 сарын 30**-ны өдрийн **А/79** тоот тушаалаар тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов.

Улсын бүртгэлийн дугаар:	**40-0031668**
Мэдүүлгийн бүртгэлийн дугаар :	**40-2024-0036838**
Анхдагч огноо :	**2024.10.15**
Эзэмшигчийн нэр :	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам**
Эзэмшигчийн хаяг :	**Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр**
Хүчинтэй байх хугацаа :	**2034.10.15**
Бараа, үйлчилгээний олон улсын ангилал :	**42**
Гэрчлэх тэмдэг:	

БАТАЛГААЖСАН
Монгол ОРГАНИК бүтээгдэхүүн

ДАРГА Г.ЭЛБЭГСАЙХАН

0013345

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын **2025 оны 6 сарын 30**-ны өдрийн **А/79** тоот тушаалаар тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов.

Улсын бүртгэлийн дугаар:	**40-0031665**
Мэдүүлгийн бүртгэлийн дугаар :	**40-2024-0036835**
Анхдагч огноо :	**2024.10.15**
Эзэмшигчийн нэр :	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам**
Эзэмшигчийн хаяг :	**Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр**
Хүчинтэй байх хугацаа :	**2034.10.15**
Бараа, үйлчилгээний олон улсын ангилал :	**42**
Гэрчлэх гэмдэг:	

БАТАЛГААЖСАН
ОРГАНИК ХӨДӨ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

ДАРГА Г.ЭЛБЭГСАЙХАН

0013348

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын **2025 оны 6 сарын 30**-ны өдрийн **А/79** тоот тушаалаар тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов.

Улсын бүртгэлийн дугаар:	**40-0031667**
Мэдүүлгийн бүртгэлийн дугаар :	**40-2024-0036837**
Анхдагч огноо :	**2024.10.15**
Эзэмшигчийн нэр :	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам**
Эзэмшигчийн хаяг :	**Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр**
Хүчинтэй байх хугацаа :	**2034.10.15**
Бараа, үйлчилгээний олон улсын ангилал :	**42**
Гэрчлэх тэмдэг:	

БАТАЛГААЖСАН ОРГАНИК Үйлчилгээ

ДАРГА Г.ЭЛБЭГСАЙХАН

0013346

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын **2025 оны 6 сарын 30**-ны өдрийн **А/79** тоот тушаалаар тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов.

Улсын бүртгэлийн дугаар:	**40-0031662**
Мэдүүлгийн бүртгэлийн дугаар :	**40-2024-0036832**
Анхдагч огноо :	**2024.10.15**
Эзэмшигчийн нэр :	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам**
Эзэмшигчийн хаяг :	**Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр**
Хүчинтэй байх хугацаа :	**2034.10.15**
Бараа, үйлчилгээний олон улсын ангилал :	**42**
Гэрчлэх тэмдэг:	

ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН Монгол ОРГАНИК бүтээгдэхүүн

ДАРГА Г.ЭЛБЭГСАЙХАН

0013352

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР
БАРААНЫ ТЭМДГИЙН ГЭРЧИЛГЭЭ

ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын **2025 оны 6 сарын 30**-ны өдрийн **А/79** тоот тушаалаар тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов.

Улсын бүртгэлийн дугаар:	**40-0031671**
Мэдүүлгийн бүртгэлийн дугаар :	**40-2024-0036841**
Анхдагч огноо :	**2024.10.15**
Эзэмшигчийн нэр :	**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам**
Эзэмшигчийн хаяг :	**Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр**
Хүчинтэй байх хугацаа :	**2034.10.15**
Бараа, үйлчилгээний олон улсын ангилал :	**42**
Гэрчлэх тэмдэг:	

ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН ОРГАНИК Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ

ДАРГА Г.ЭЛБЭГСАЙХАН

0013342